



**УЛААНБААТАР ХОТЫН
ЕРӨНХИЙ МЕНЕЖЕРИЙН
ТУШААЛ**

2019 оны 03 сарын 06 өдөр

Дугаар A/57


Улаанбаатар хот

**Архивын баримтын тавиур худалдан
авах тухай**

Төсвийн тухай хуулийн 16 дугаар зүйлийн 16.5.4, 16.5.5, Архивын тухай хуулийн 9 дүгээр зүйлийн 9.2.1, 9.2.3, Нийслэлийн Засаг даргын 2014 оны А/279 дүгээр захирамжаар батлагдсан "Захирамжлалын баримт бичиг боловсруулах, батлах, хянах, мэдээлэх журам"-ын 2 дугаар хэсгийн 2.4.1, Үндэсний архивын газрын даргын 2007 оны 59 дүгээр тушаалаар батлагдсан "Байгууллагын архивын ажлын үндсэн заавар", Улаанбаатар хотын Захирагчийн ажлын албаны дүрмийн 2 дугаар хэсгийн 2.9.5 дахь заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Байгууллагын архивын сан хөмрөгт архивын баримтын нөхөн бүрдүүлэлт хийх багтаамжгүй болсонтой холбогдуулан заавар журам, стандартын дагуу архивын баримтын тавиур худалдан авах ажлыг зохион байгуулж, хяналт тавьж ажиллахыг Захиргаа, санхүүгийн хэлтэс /Э.Энхцэцэг/-т даалгасугай.

2. Дээрх ажилд шаардагдах 1.799.600 /Нэг сая, долоон зуун ерэн есөн мянга, зургаан зуун/ төгрөгийг багаж, хэрэгслийн зардлаас гаргахыг Ахлах нягтлан /Б.Цэрмаа/-д зөвшөөрсүгэй.

УЛААНБААТАР ХОТЫН ЕРӨНХИЙ МЕНЕЖЕР
БӨГӨӨД ЗАХИРАГЧИЙН АЖЛЫН АЛБАНЫ
ДАРГА  Т.ГАНТӨМӨР

